



# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны 07 сарын 07 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

## ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөвшөөрлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

### 1/8.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн 7.10, 7.11, 7.12 дахь заалт:

7.10.их сургууль, дээд сургуулийн харьяа мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага байгуулах	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7.11.гадаадын хөрөнгө оруулалттай мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага байгуулах	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
7.12.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын үйл ажиллагаа эрхлэх	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

### 2/8.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.14 дэх заалт:

6.14.Мэргэжлийн болон техникийн боловсролын шинэ мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
--	--

**2 дугаар зүйл.**Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “Төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд энэ хуульд заасан зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэхээс бусад” гэснийг “Энэ хуульд заасан зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаа нь” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР